



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 17d

Улаанбаатар хот

### Зөвшөөрөл олгох тухай

Засгийн газрын 2013 оны 38 дугаар тогтоолын 6 дугаар заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.8, 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТӨГТООХ нь:

1. Монгол-Солонгосын политехник коллежийн эзэмшлийн нийслэлийн Хан-Уул дүүргийн 3 дугаар хороонд байрлах сургалтын зориулалттай 18115 м.кв талбай бүхий газраас 900 м.кв газрын эзэмших эрхийг тус байгууллагад хэвээр үлдээж зориулалтыг үйлчилгээтэй орон сууцны болгон өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2. Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн эзэмшлийн нийслэлийн Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд байрлах сургалтын зориулалттай 12000 м.кв талбай бүхий газраас 610 м.кв газрын эзэмших эрхийг тус байгууллагад хэвээр үлдээж зориулалтыг үйлчилгээтэй орон сууцны болгон өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Монгол-Солонгосын политехник коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Цэгмид, Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Очирбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Зориулалт өөрчлөгдж байгаатай холбогдуулан санхүүгийн тайланд бүртгэлтэй эрхийн үнэлгээнд өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор судлан, саналаа ирүүлэн шийдвэрлүүлэх;

3.2. Авсан арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-түүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ